



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/455

Арвайхээр сум


Буцалтгүй тусламж үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 16 дугаар зүйлийн 16.1, Нийгмийн халамжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.9, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн бага ангийн багш Б.Адъяа нь хорт хавдартай оношлогдсон тул эмчилгээний зардалд 1,000,000 (нэг сая) төгрөг, мөн онош тодорхойгүйгээр Солонгос улсад эмчилгээ хийлгэж байгаа хүнд өвчтэй Б.Эрдэмбилэг хүүд 1,000,000 (нэг сая) төгрөг, нийт 2,000,000 (хоёр сая) төгрөгийн нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж үзүүлсүгэй.

2. Дээрх зардлыг Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0882

D:My Doc. Zahiramj. Zasag darga